

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Марсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/230
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Т.АНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Үүр сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Үүр сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 33,268.9 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 56,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 22,040.0 мянган төгрөг нийт 78,040.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, эмнэлгийн 28 ажиллагсад /БГАҮЗ, БҮБЗ/ төсвийн хөрөнгөөс 3,080.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гарган ноосон цамц, өмд худалдан авсан, Ковид 19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын 9,944.5 мянган төгрөгийн үнэ бүхий 1,113 ширхэг вакцины хугацаа дууссан гэж данснаас хассан ба уг вакциныг устгаагүй ямар нэгэн анхан шатны баримтгүй шууд данснаас хасаж тайлагнасан гэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 87.3 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон

улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 29/2023/0439/ХАА-2023/66
/НА-ЦА-ТШЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын төсвөөс эмнэлгийн ажилтнуудад ноосон цамц, өмд худалдан авч 3,080,000 (Гурван сая наян мянган) төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4."хуулиар зөвшөөрөөгүй бусад" зардал гаргахыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Байгууллагын төсвөөс зарцуулсан 3,080,000 (гурван сая наян мянган) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Т.Анхжаргал, нягтлан бодогч Б.Золжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>217,095,138.32</u>	<u>182,608,746.69</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	33,268,860.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	33,268,860.00
3121	Төгрөг	00.00	33,268,860.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	33,268,860.00
33	АВЛАГА	105,783,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	105,783,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	111,312,138.32	149,339,886.69
351	Түүхий эд материал	78,723,774.32	69,253,624.74
35110	Тусгай зориулалттай материал	19,335,475.40	00.00
35130	Эм боох материал	59,388,298.92	69,253,624.74
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	00.00
354	Хангамжийн материал	32,588,364.00	80,086,261.95
35410	Бичиг хэргийн материал	195,000.00	679,900.00
35420	Аж ахуйн материал	583,000.00	22,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	5,916,600.00	2,638,124.00
35450	Барилгын засварын материал	8,400.00	00.00
35460	Хүнсний материал	3,025,240.00	7,679,280.00
35470	Бусад хангамжийн материал	22,860,124.00	69,066,457.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>302,871,173.63</u>	<u>330,229,802.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	302,871,173.63	330,229,802.60
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	286,395,173.63	313,753,802.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	216,015,094.58	216,015,094.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,762,647.93	-78,231,891.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,870,000.00	76,016,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,094,444.10	-42,545,305.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,465,740.36	164,105,878.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,890,548.31	-52,789,592.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,020,000.00	17,690,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,406,030.82	-4,390,124.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,666,393.70	30,616,393.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,488,383.85	-12,732,650.60
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	00.00	00.00
393	Биет бус хөрөнгө	16,476,000.00	16,476,000.00
39301	Програм хангамж	781,470.00	781,470.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-781,470.00	-781,470.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,476,000.00	16,476,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>519,966,311.95</u>	<u>512,838,549.29</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>519966311.95</u>	<u>512838549.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	519,966,311.95	512,838,549.29

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	416,783,360.00	416,783,360.00
51101	Өмч: - төрийн	416,783,360.00	416,783,360.00
512	Хуримтлагдсан үр дүн	-65,227,304.81	-72,355,067.47
51210	Өмнөх үеийн үр дүн	-65,227,304.81	-65,227,304.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,127,762.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	168,410,256.76	168,410,256.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>519,966,311.95</u>	<u>512,838,549.29</u>

СТ-2А

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,549,933.34	711,300,662.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	306,701,558.34	93,507,402.90
120	Нийтлэг татварын бус орлого	306,701,558.34	93,507,402.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	306,701,558.34	93,507,402.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	306,701,558.34	93,507,402.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,229,575.00	617,793,260.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,618,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	264,370,165.00	1,191,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	158,587,165.00	1,191,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,783,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,260,000.00	32,089,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,260,000.00	32,089,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,599,410.00	584,512,460.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,599,410.00	584,512,460.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	821,942,715.62	718,428,425.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,942,715.62	718,428,425.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,542,715.62	718,428,425.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,305,500.00	403,520,700.00
210101	Үндсэн цалин	194,036,100.00	274,751,520.00
210102	Нэмэгдэл	108,668,300.00	62,304,591.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,760,000.00	3,608,000.00
210104	Урамшуулал	41,132,600.00	62,856,589.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,708,500.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,466,204.00	50,303,200.00
210201	Тэтгэврийн даатгал	34,105,336.00	38,335,718.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,598,302.00	2,926,098.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,878,641.00	2,606,401.94
210204	Ажилгүйдлийн даатгал	711,885.00	582,782.38
210205	Эрүүл мэндийн даатгал	7,172,040.00	5,852,198.29
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,354,800.00	24,038,076.00

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	2,499,729.00	2,361,476.00
210302	Түлш, халаалт	14,295,071.00	21,116,600.00
210303	Цэвэр, бохир ус	560,000.00	560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,935,265.00	54,612,650.00
210401	Бичиг хэрэг	1,993,400.00	7,524,834.00
210402	Тээвэр, шатахуун	21,138,665.00	23,545,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,790,000.00	2,821,966.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,252,500.00	1,585,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,560,700.00	19,134,650.00
2105	Нормативт зардал	266,964,006.74	118,110,580.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	254,195,474.74	104,653,845.47
210502	Хоол, хүнс	12,768,532.00	13,456,735.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	17,499,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	15,299,900.00
2107	Томилолт, зочны зардал	928,000.00	1,377,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	928,000.00	1,377,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,326,256.00	2,507,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,081,496.00	1,304,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	849,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	164,760.00	164,760.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,100,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,762,683.88	46,459,009.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,870,450.00	5,411,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,892,233.88	41,047,509.09
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	196,607,217.72	-7,127,762.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,000,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,000,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,000,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	181,607,217.72	-7,127,762.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	606,065,375.00	723,576,260.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	606,065,375.00	723,576,260.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,618,800.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,587,165.00	1,191,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	158,587,165.00	1,191,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,260,000.00	32,089,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,260,000.00	32,089,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,599,410.00	690,295,460.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,599,410.00	690,295,460.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	599,945,375.00	660,451,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	599,945,375.00	660,451,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,545,375.00	660,451,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,305,500.00	403,520,700.00
210101	Үндсэн цалин	194,036,100.00	256,598,582.88
210102	Нэмэгдэл	108,668,300.00	78,619,997.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,760,000.00	3,912,000.00
210104	Урамшуулал	41,132,600.00	64,390,120.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,708,500.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,466,204.00	50,303,200.00
210201	Тэтгэврийн даатгал	33,913,004.00	35,313,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,076,100.00	3,748,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,646,600.00	2,998,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	938,200.00	747,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,892,300.00	7,495,900.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,760,000.00	20,759,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,499,729.00	2,361,476.00
210302	Түлш, халаалт	14,700,271.00	17,838,124.00
210303	Цэвэр, бохир ус	560,000.00	560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,019,365.00	45,846,890.00
210401	Бичиг хэрэг	1,993,400.00	2,954,634.00
210402	Тээвэр, шатахуун	21,138,665.00	23,545,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,790,000.00	2,821,966.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	83,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,465,500.00	2,758,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,431,800.00	13,683,000.00
2105	Нормативт зардал	84,589,600.00	97,370,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,243,028.00	70,012,200.00
210502	Хоол, хүнс	15,346,572.00	15,458,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	11,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,280,000.00	25,265,000.00

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	780,000.00	270,000.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	10,500,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	14,495,000.00
2107	Томилолт, зочны зардал	928,000.00	1,377,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	928,000.00	1,377,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,326,256.00	7,270,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,081,496.00	4,249,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	849,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	164,760.00	164,760.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,100,000.00	1,817,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,870,450.00	8,738,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,870,450.00	8,738,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,120,000.00</u>	<u>63,125,160.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,120,000.00	29,856,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,120,000.00	29,856,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,120,000.00	29,856,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-6,120,000.00</u>	<u>-29,856,300.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	33,268,860.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	33,268,860.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,307,360.00	11,036,542.70	-145,831,231.87	265,512,670.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,944,200.00	2,944,200.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,307,360.00	11,036,542.70	-142,887,031.87	268,456,870.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-2,944,200.00	00.00	-2,944,200.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,137,091.30	-11,137,091.30

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	416,783,360.00	168,410,256.76	-65,227,304.81	519,966,311.95
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	416,783,360.00	168,410,256.76	-65,227,304.81	519,966,311.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	416,783,360.00	168,410,256.76	-65,227,304.81	519,966,311.95
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,127,762.66	-7,127,762.66
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	416,783,360.00	168,410,256.76	-72,355,067.47	512,838,549.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	692,184,600.00	690,307,400.00	1,877,200.00	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,184,600.00	690,307,400.00	1,877,200.00	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	692,184,600.00	690,307,400.00	1,877,200.00	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,520,700.00	403,520,700.00	0.00	100
210101	Үндсэн цалин	256,598,582.88	256,598,582.88	0.00	100
210102	Нэмэгдэл	78,619,997.12	78,619,997.12	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,912,000.00	3,912,000.00	0.00	100
210104	Урамшуулал	64,390,120.00	64,390,120.00	0.00	100
210105	Гэрээт ажлын хөлс	13,646,100.00	00.00	13,646,100.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,303,200.00	50,303,200.00	0.00	100
210201	Тэтгэврийн даатгал	35,313,600.00	35,313,600.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	3,748,000.00	3,748,000.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,998,400.00	2,998,400.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	747,300.00	747,300.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	7,495,900.00	7,495,900.00	0.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,759,600.00	20,759,600.00	0.00	100
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,361,476.00	638,524.00	100
210302	Түлш, халаалт	17,199,600.00	17,838,124.00	-638,524.00	100
210303	Цэвэр, бохир ус	560,000.00	560,000.00	0.00	100
210304	Байрны түрээс	00.00	00.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	46,331,700.00	45,846,890.00	484,810.00	99
210401	Бичиг хэрэг	1,769,100.00	2,954,634.00	-1,185,534.00	167
210402	Тээвэр, шатахуун	23,545,500.00	23,545,500.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,007,500.00	2,821,966.00	1,185,534.00	70.4
210404	Ном, хэвлэл	83,500.00	83,500.00	0.00	100

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,243,100.00	2,758,290.00	484,810.00	85.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,683,000.00	13,683,000.00	0.00	100
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00	0.00	100
2105	Нормативт зардал	97,370,400.00	97,370,400.00	0.00	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,012,200.00	70,012,200.00	0.00	100
210502	Хоол, хүнс	15,458,200.00	15,458,200.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,900,000.00	11,900,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,121,300.00	55,121,300.00	0.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,126,300.00	30,126,300.00	0.00	100
210602	Тавилга	00.00	00.00	0.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,500,000.00	10,500,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	14,495,000.00	14,495,000.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,377,000.00	1,377,000.00	0.00	100
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	1,377,000.00	1,377,000.00	0.00	100
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,662,400.00	7,270,010.00	1,392,390.00	83.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,249,700.00	4,249,700.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	849,600.00	849,600.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	133,950.00	226,050.00	37.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,400.00	00.00	260,400.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,400.00	55,000.00	20,400.00	72.9
210807	Газрын төлбөр	271,200.00	164,760.00	106,440.00	60.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,596,100.00	1,817,000.00	779,100.00	70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8738300.00	8738300.00	0.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,738,300.00	8,738,300.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	690,889,300.00	723,576,260.00	-32,686,960.00	105
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	0.00	0
131001	Улсын төсвөөс санхүүжих	32,089,800.00	32,089,800.00	0.00	100

132001	Орон нутгийн төсвөөс	32,089,800.00	32,089,800.00	0.00	100
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	658,799,500.00	691,486,460.00	-32,686,960.00	105
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	511,920,500.00	551,910,260.00	-39,989,760.00	108
134003	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	146,879,000.00	139,576,200.00	7,302,800.00	95
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	33,268,860.00	-33,268,860.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00		100
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00		0
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00		100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00		100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Цагаан-үүр сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

¹ "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

² "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай"

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Цагаан-үүр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 9-р сарын 19-ны өдрийн А/18 тоот тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 заалт бүхий 7 арга хэмжээний хүрээнд хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан

боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,127.8 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	33,268.9	33,268.9
Авлага	105,783.0	0	-105,783.0
Бараа материал	111,312.1	149,339.8	38,027.7
Үндсэн хөрөнгө	302,871.1	330,229.8	27,358.7
Нийт хөрөнгө	519,966.3	512,838.5	-7,127.8
Өр төлбөр		0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	519,966.3	512,838.5	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	519,966.3	512,838.5	-7,127.8

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данснуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 33,268.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 38,027.7 мянган төгрөгөөр өссөн нь эм, бусад хангамжийн материалын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 27,358.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 68,406.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 29,853.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй буюу улсын төсөв, орон нутгийн төсвөөс 38,549.8 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Өмнөх оны эрүүл мэндийн даатгалаас авах авлага 105,783.0 мянган төгрөгийн бүрэн барагдуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 584,512.5 төгрөг, Орон нутгийн төсвөөс 32,089.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөсөн. Нийт зарлагыг 616,602.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 07-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,877.2 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 584,512.5

мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр, 32,089.8 мянган төгрөгийг орон нутгийн урсгал санхүүжилтийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 584,512.5 сая төгрөг, орон нутгийн орлогоос 32,089.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 723,576.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,877.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсан, мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 33,268.9 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	289,815,3	289,815.3		100.0%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	222,105,2	254,792.1	32,686.8	86.3%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	146,879,0	146,879.0	0	100%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	23,259,6	23,259.6	0	100%
5	Нийтлэг үйлчилгээ	8,830,2	8,830.2	0	100%
	Нийт дүн	690,889.3	723,576.1	32,686.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 103,783.0 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаан-үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаан-үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 821,942.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,438.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл хугацаандаа, 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 587,759.4 мянган төгрөгийн 12 гүйлгээний мэдээлэл оруулахаас 64,125.3 мянган төгрөгийн 2 гүйлгээг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.
1. “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ээс 7.8 дугаар саруудын мэдээллийг огт мэдээлээгүй зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтуудыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар аудитын явцад шилэн дансны мэдээлэлд 14,100.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулж, 1 албан шаардлага өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	14,100.0		14,100.0	100
Нийт дүн	1	14,100.0		14,100.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 56,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 22,040.0 мянган төгрөг нийт 78,040.0 мянган төгрөг байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 207,443.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 117,109.1 мянган төгрөгийн алдааг залруулж, төлбөрийн акт 3080.0 мянган төгрөг, 87,254.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 105,783.0 мянган төгрөгийг 2022 оны Мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үнэ төлбөргүй орлого авсан үндсэн хөрөнгө, бараа материалын дүн зөрүүтэй 2,341.7 мянган төгрөг
- Тайлант онд 8,985.0 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 90,334.0 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, төлбөрийн акт 3,080.0 мянган төгрөг, 87,254.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Эмнэлгийн 28 ажиллагсад 76 ширхэг 8,820.0 мянган төгрөгийн нормын хувцас тушаал шийдвэргүй /БГАҮЗ, БҮБЗ/ төсвийн хөрөнгөөс худалдан авснаас ноосон цамц, өмдний 3,080.0 мянган төгрөгийн илүү зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “ Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ковид 19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын 9,944.5 мянган төгрөгийн үнэ бүхий 1,113 ширхэг вакцины хугацаа дууссан гэж данснаас хассан ба уг вакциныг устгаагүй ямар нэгэн анхан шатны баримтгүй шууд данснаас хасаж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү 5,004.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

3. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 5,051.7 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

4. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 5,128.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

5. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл хугацаандаа, 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 587,759.4 мянган төгрөгийн 12 гүйлгээний мэдээлэл оруулахаас 64,125.3 мянган төгрөгийн 2 гүйлгээг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ээс 7.8 дугаар саруудын мэдээллийг огт мэдээлээгүй зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	105,783.0			1	105,783.0	1	105,783.0				
Үнэ төлбөргүй орлого авсан үндсэн хөрөнгө, бараа материалын дүн зөрүүтэй	1	2,341.7			1	2,341.7	1	2,341.7				
Эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	8,985.0			1	8,985.0	1	8,985.0				
Дүн	3	117,109.0			3	117,109.0	3	117,109.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн	1	3,080.0	1	3,080.0								

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийг зориулалтаар нь зарцуулагүй	1	5,051.7				1	5,051.7				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал авсан	1	5,004.0				1	5,004.0				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	5,128.3				1	5,128.3				
Дүн	5	28,208.7	1	3,080.0		4	25,128.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	62,125.3					1	62,125.3
Дүн	1	62,125.3					1	62,125.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЕМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

